



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 1/405

Мөрөн сум

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн баяр наадмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан баталсан аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/380 дугаар захирамжийн хавсралтын 7 дахь хэсэг буюу “Ёслол хүндэтгэл, мэдээлэл сурталчилгааны салбар хороо” баганад, бичилт болон тооцооны алдаа түүнтэй адилтгаж болохоор өөр бусад илэрхий алдааг залруулах зорилгоор дараах байдлаар өөрчлөлт оруулсугай. Үүнд:

1.1 Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Зардал батлах тухай” А/374 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Түрүүлж айрагдсан морьдын бай шагналын зардал”-аас хэмнэгдсэн 3,600,000 (Гурван сая зургаан зуун мянган) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Зардал батлах тухай” А/380 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Ёслол хүндэтгэл, мэдээлэл сурталчилгааны салбар хороо”-ны зардлыг 3,600,000 (Гурван сая зургаан зуун мянга) төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

2. Төсвийг өөрчлөлтийн дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг баяр наадмыг зохион байгуулах хорооны дарга, аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

